



ЛҮН СУМЫН ЕБСУРГУУЛЬ

2013 оны Санхүүгийн Тайлан

Үндэсний Аудитын газрын харьяа Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Дарга, Тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582

Аудитын менежер
О.Амаржаргал
Утас: 70273463

Шинжээч Ц.Хишигжаргал
Утас: 70273204
И-мэйл khj_616@yahoo.com

Хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

- Танилцуулга 3
- Санхүүгийн дотоод хяналт 3-7
- Гол шийдлүүд 7
- Залруулаагүй алдаа... 7
- Тайлбар мэдүүлгийн захидал.... 7
- Аудитын санал дүгнэлт..... 7

Лүн сумын ЕБСургуулийн 2013 оны Санхүүгийн Тайланд**ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Лүн сумын ЕБСургуулийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. Лүн сумын ЕБСургуулийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаах бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Лүн сумын удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулвал:

Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулвал:

Дотоод хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй хийгээгүй байна.

- ✓ Илүү зарцуулсан нүүрсний үнэ 1306.2 мянган төгрөгийг байгууллагаар төлүүлэх төлбөрийн акт бичив.
- ✓ Тусгай зориулалтын дансанд бөөн дүнгээр буюу 1746.2 мянган төгрөгийн 1 ширхэг 19 см-ийн таваг гэж бүртгэсэн байгааг хөрөнгийн нэр төрлөөр салгаж, ангилалыг зөв дансанд бүртгэх.
- ✓ Кассын тайлан болон анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.
- ✓ Илүү төлсөн татвар 334.0 мянган төгрөг болон түрээсийн орлогын дутуу 200.0 мянган төгрөг нийт 534.0 мянган төгрөгийг байгууллагаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх акт бичив.
- ✓ Мөн сургуулийн байранд Чи-Мэ хоршоо үйл ажиллагаа явуулж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.1.-д “Төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно” гэсэнтэй зөрчилдөж байна.

ЕМ, Санхүүгийн албанаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү.

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн хөрөнгө бараа материалыг нэр төрөл, тоо ширхэгийг зөв тайлагнахтай холбогдон гарсан зөрчлүүдийг арилгуулахаар албан шаардлага бичиж тус тайланд **зөрчилгүй** дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа

Тэргүүлэх аудитор 2014.03.19-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч М.Баттунгалаг нар бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Үндэсний Аудитын Газрын Харьяа Төв
Аймгийн Аудитын Газар

2014.03.18

Танилцуулга

1. Бид Лүн сумын ЕБСургуулийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. ЕБСургуулийн удирдлагуудад аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Лүн сумын ЕБСургуулийн удирдлагууд тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
 2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.
- Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

3. ААГазар нь санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Лүн сумын ЕБСургуулийн дотоод хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Лүн сумын ЕБСургуулийн удирдлагад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараах түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Лүн сумын ЕБСургуулийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналт шалгалтын талаар

МУ-ын ЗГазрын 2011.11.09-ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” –ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэсэн заасан байдаг.

Жилийн эцэст дотоод хяналтын шалгалт хийгдсэн тайлан авчраагүй ба хяналт шалгалт хийсэн тухай тайланг тухай бүрд нь бичиж тайланг бичсэн гэх боловч санхүүгийн үйл ажиллагаатай холбогдуулан хяналт шалгалт хийсэн тайлан байхгүй байна.

- ✓ МУ-ын ЗГазрын 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллахыг дахин зөвлөж байна.

2. Орлого санхүүжилтийн талаар

Лүн сумын Сургууль нь 2013 онд төсвөөс санхүүжүүлсэн 484817.2 мянган төгрөг авч үйл ажиллагаа явуулсан ба өөрийн орлого 140.0 мянган төгрөг төлөвлөсөн байна. Санхүүжилтыг 484817.2 мянган төгрөгийг бүрэн авсан, түрээсийн орлого 400.0 мянган төгрөг, листны мөнгө 1672.6 мянган төгрөг, бусад орлого 41.7 мянган төгрөг нийт 484817.2 мянган төгрөгийн орлогыг тайланд зөв бүртгэж тусгасан байна.

3.Үндсэн хөрөнгө

ЕБСургуулийн үндсэн хөрөнгө нь оны эхэнд 434542.6 мянган төгрөг дээр 69620.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, хасагдсан хөрөнгө байхгүй 424236.6 үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд: барилга байгууламжийн дансанд 14217.2 мянган төгрөг, Авто тээврийн хэрэгсэлд 6500.0 мянган төгрөгийн микро автобус, Тоног төхөөрөмж дансанд 23178.3 мянган төгрөгийн, тавилга хэрэгсэл 23171.0 мянган төгрөг Номын фондонд 1951.3 мянган төгрөг нийт 69017.8 мянган төгрөгийн хөрөнгө сургуулийн 90-н жилийн ойн хандив тусламжаас үнэ төлбөргүй орсон байна. Мөн өөрийн хөрөнгөөр Номын фондонд 570.0 мянган төгрөгийн, Программ хангамжийн дансанд 33.0 мянган төгрөгийн цалингийн программ тус тус авсан байна. Үндсэн хөрөнгийн дансанд Урсгал засвар 19878.2 мянган төгрөг, сургуулийн барилга-2 37129.5 мянган төгрөг, тоног төхөөрмжийн үнийн зөрүү 1079.9 мянган төгрөг зэрэг нэр төрөл зөрүүтэй бүртгэгдсэн байгааг залруулан бүртгэх албан шаардлага бичив.

- ✓ Урсгал зардалаас 570.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.
- ✓ Нэр төрөл зөрүүтэй буюу буруу бүртгэсэн үндсэн хөрөнгийг залруулан бүртгэх албан шаардлага бичив.

4.Бараа материал.

Тайлант онд бараа материалын тайлангаар 69002.8 мянган төгрөгийн орлогын, 72651.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж жилийн эцэст 23447.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Бараа материалын дансаар бичиг хэргийн материалд 1637.0 мянган төгрөг худалдан авч 2778.3 мянган төгрөг зарцуулсан, аж ахуйн материалд 3109.6 мянган төгрөгийн орлого авч 3047.8 мянган төгрөг зарцуулсан, түлш шатах тослох материалд 19238.2 мянган төгрөгийн орлого авч 21113.2 мянган төгрөгийн халаалт болон шатахууны зардал гарсан, хүнсний материал 42367.8 мянган төгрөгийн орлого авч 42529.9 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан байна. Эм боох материалын дансанд 22.7 мянган төгрөгийн орлого авч зардал гараагүй байна. Тусгай зориулалтын материал дансанд 1746.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Бараа материалын дансанд уурын зуух 9136.9 мянган төгрөг, мөн уурын зуух 10891.3 мянган төгрөг, С.Ганбаатар-1ш 6485.4 мянган төгрөг /юу нь тодорхой бус/, уран зохиолын ном-1ш 507.1 мянган төгрөг зэрэг нэр төрөл, тоо ширхэг зөрүүтэй байгааг залруулан бүртгэх шаардлагатай байна. Түлш халаалтын зардалд байгууллагын өөрийн уурын зуух ажилаж байсан хугацааны нүүрсний зарцуулалтыг, НР16Ж, НР30Ж уурын зуухны хүчин чадал, норматив, ажилласан хугацаа зэрэгт харгалзан тооцож үзэхэд нийт 277 тн нүүрс зарцуулсан ба оргил ачаалалтай үеийн нормативээр 256 тн нүүрс зарцуулах байжээ. Иймээс илүү зарцуулсан 21 тн нүүрсийг тухайн хугацааны 1-тн нүүрсний дундаж үнэ болох 62200 төгрөгөөр тооцож нийт 1306.2 мянган төгрөгийн нүүрсийг илүү зарцуулсан байна.

- ✓ Илүү зарцуулсан нүүрсний үнэ 1306.2 мянган төгрөгийг байгууллагаар төлүүлэх төлбөрийн акт бичив.
- ✓ Тусгай зориулалтын дансанд бөөн дүнгээр буюу 1746.2 мянган төгрөгийн 1 ширхэг 19 см-ийн таваг гэж бүртгэсэн байгааг хөрөнгийн нэр төрлөөр салгаж, ангилалыг зөв дансанд бүртгэх.

5.Цалингийн талаар

Цалингийн сан үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангаар тус байгууллагуудад нийт 306421.9 мянган төгрөг тайлагнагдсан байна. Ажилчдын цалингаас ХАОАТатвар 24206.6 мянган төгрөг суутгасан боловч Татварын хэлтэст 24540.6 мянган төгрөг шилжүүлж 334.0

мянган төгрөг илүү төлсөн ба авлагаар тайлагнаагүй, НДШимтгэл 30391.7 мянган төгрөг суутгасан мөн байгууллагаас НДШимтгэл 33691.7 мянган төгрөг тооцож нийт 64083.4 мянган төгрөг төлсөн байна. Ажилчдын цалингийн картанд шилжүүлсэн 241524.6 мянган төгрөгийг цалингийн цэстэй тулган шалгахад тохирч байна. Цалинг бодож олгоход 2012 оны 78-р тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээг баримтлан ЗГазрын 2001 оны үндэслэн 90-р тогтоолын дагуу урамшууллыг зөв тогтоож олгосон байна.

- ✓ Цалингийн цэс болон цагийн бүртгэлд гарын үсэг зуруулж хэвшүүлэх

6.Бараа үйлчилгээний зардал

Бараа ажил үйлчилгээний зардал 103640.9 мянган төгрөг батлагдсан ба төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 102511.5 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнээс түлш халаалтын зардал 41848.8 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 4236.0 мянган төгрөг, хоол хүнсний материалд 28675.7 мянган төгрөг, үдийн цайнд 16559.2 мянган төгрөг зэрэг зардлууд голлох дүнг эзэлж байна. Жилийн эцэст үлдсэн 1877.6 мянган төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлж бараа үйлчилгээний зардлын дүнд тусгасан байна.

- ✓ Авто машинаар ажил гүйцэтгэсэн тухай тайлан тэмдэглэгээ жолоочийн замын хуудсанд тодорхой бичиж зардалд тусгаж байх.

Мөнгөн хөрөнгө

Тайлант онд байгууллагын харилцах болон кассаар 487189.8 мянган төгрөг зарцуулсанаас кассаар 955.7 мянган төгрөг авч зарцуулсан байна. шгнал урамшуулал ажлын хөлс зэрэг зүйлст зарцуулсан ба татварыг суутган авч татварын хэлтэст тушаасан байна. Кассаар дамжуулан зарцуулсан дээрх мөнгөнд бичсэн чек болон кассанд орлого авсан дүнгүүд хоорондоо зөрүүтэй байна. Анхан шатны баримтын бүрдэл муу байгаа нь кассын няравын хариуцлаггүй байгааг харуулж байна. Иргэн Мөнхболдоос авсан нүүрсний үнэ 700.0 мянган төгрөгийн 10% болох 70.0 мянган төгрөг иргэдээс авсан мах, төмсний үнээс суутгаж аваагүй 243.7 мянган төгрөгийг нөхөж авах төлбөрийн акт бичив. Оны эцэст харилцах дансанд 1877.6 мянган төгрөг үлдсэнийг онд нь багтааж татан төвлөрүүлсэн байна.

- ✓ Кассын тайлан болон анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.
- ✓ Бэлнээр өгч буй шагналын мөнгө, ажлын хөлснөөс 10% суутган авч орлогод төвлөрүүлж байх.

8.Авлага, өглөгийн талаар

Тайлант онд нэг ч төгрөгийн авлага үүсгээгүй гэж тайлагнасан боловч татварын хэлтэст илүү төлсөн 334.0 мянган төгрөг, Чи-Мэ хоршооноос түрээсийн орлогын дутуу 200.0 мянган төгрөг нийт 534.0 мянган төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй байна. Мөн 71.5 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна. Мөн цалин, НДШ, ХАОАТ зэрэгт нийт 426643.5 мянган төгрөг бусад бараа үйлчилгээнд 155650.2 мянган төгрөг нийт 582293.8 мянган төгрөгийн өглөг үүсгэж барагдуулсан байна. Тайлант онд харилцагч байгууллагууд болох НДХэлтэс, Татварын алба, Чи-Мэ хоршоо, Шунхлай трэйд, Эрчим хүчний салбар зэрэг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж гарсан гүйлгээг сар бүрээр тулган баталгаажуулсан байна. Гэвч тайлангийн дундуур данс бүртгэлд өглөгөөр тусгаагүй байхад Алтан сүлдэт мөнх ХХК-д 2013 оны 12-р сарын 24-нд нүүрсний үнэ 1080.0 мянган төгрөг, Юу Эй Арти ХХК-д 10-р сарын 07-нд 718.8 мянган төгрөг нүүрсний үнэ гэж шилжүүлсэн байна. Дээрх хугацаанд тус байгууллага нь Ану сервис ХХК-иас халаалт авч төсөвлөгдсөн мөнгийг дүнгээр нь шилжүүлж байсан байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөг, авлага тусгагдаагүй байна.

- ✓ Илүү төлсөн татвар 334.0 мянган төгрөг болон түрээсийн орлогын дутуу 200.0 мянган төгрөг нийт 534.0 мянган төгрөгийг байгууллагаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх акт бичив.
- ✓ Мөн сургуулийн байранд Чи-Мэ хоршоо үйл ажиллагаа явуулж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.1.-д “Төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно” гэсэнтэй зөрчилдөж байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн хяналтын талаар удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн. Эдгээр асуудлуудыг Аудитын газар болон Лүн сумын ЕБСургуулийн удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн болно.

Залруулагдаагүй алдаа

6. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын Газар аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч мянган төгрөгийг аудитын явцад залруулсан болно

Тайлбар мэдүүлгийн захидал

7. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтнаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

8. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Үндэсний Аудитын Газрын Харьяа Аймгийн Аудитын газар

2014.03.18